



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2027. 09. 04 № 795-154-12/1691
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/202401031279 дугаартай “Эрчим хүчний менежментийн тогтолцооны ISO50001 стандартыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний ажил”-ын тендерт ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт¹... хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

612407038020

2023.12.12 / 14.41



2023 оны 01
дугаар сарын 07 -ны өдрийн
дугаар албан бичгийн хавсралт

Тодруулгын хариу

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн цахим системийн шинэчлэлтэй холбоотойгоор 2023 оны сүүлийн 3 сарын лавлагааг ирүүлэх боломжтой.

2. IRCA (International Register of Certified Auditors) болон EA (Exemplar Global) нь гэрчилгээ олгодог байгууллага биш бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын сургалтын байгууллагыг итгэмжилдэг тухайн итгэмжлэгдсэн сургалтын байгууллагаас гэрчилгээ авсан мэргэжилтэн нь гэрчилгээжсэн олон улсын стандартын талаар мэдлэг, ур чадвар, туршлагатай гэдгийг нотлох боломжтой мэргэжилтний бүртгэлийн систем юм.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар энэ чиглэлийн мэргэжилтнийг шалгах, бүртгэх систем хараахан хөгжөөгүй хэдий ч дотоодын мэргэжилтнүүд онлайн сургалтын платформ ашиглах төдийгүй гадны улс оронд очиж итгэмжлэгдсэн сургалтын байгууллагаас олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн агуулгын дагуу сургалтанд сууж, шалгалт өгч тэнцсэнээр гэрчилгээ авах боломж бүрдсэн байдаг.

Энэхүү мэргэжилтний чадамжийн нотолгоо нь аль нэг сургалтын байгууллага, компанийг онцолж, давуу тал олгоогүй бөгөөд сургалтын байгууллагын чадамжийн нотолгооны шалгуур юм.

3. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаардахгүй тул Маягт №3-ыг ирүүлэхгүй байж болно.

4. Зөвлөх үйлчилгээний ISO 20700 стандартыг хэрэгжүүлэн ажилладаг зөвлөх үйлчилгээний байгууллага нь төслийн бүх үе шатанд үйлчилгээгээ ил тод, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар хүргэхэд туслах төдийгүй, зөвлөн туслах үйлчилгээ захиалагч байгууллагуудад эхний ээлжинд зөвийг нь олоход тусална. Дэлхийн шилдэг туршлага, тодорхой шалгууруудыг нэгтгэснээр үйлчлүүлэгч, зөвлөхүүдийн хамтран ажиллах арга барил сайжирч, зөвлөх үйлчилгээний чанар сайжирна. ISO 20700 стандарт нь удирдамжийн стандарт боловч түүнийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгааг хөндлөнгөөс баталж, нотлох боломжтой.

ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлсэн, баталгаажуулсан зөвлөх үйлчилгээний байгууллага нь захиалагч байгууллагын хэрэгцээ, шаардлагыг судлан тогтоож, тэдгээрт нийцсэн үйлчилгээ үзүүлж, сэтгэл ханамжийг байнга дээшлүүлж ажилладаг гэдгийг нотлох үндэслэл болно.